



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 2 дугаар  
сарын 10-ны өдөр


Дугаар 27

Улаанбаатар  
хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн  
байдлаар шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.2, 11.3.3, Улсын онцгой комиссын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас мөн оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.
2. Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга Д.Сумьяабазарт үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН

Засгийн газрын 2021 оны 27 дугаар тогтоолын хавсралт

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ

№	БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
1.	Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгал, хог хаягдал, нийтийн аж ахуй, инженер хангамжийн байгууллага
2.	Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл, ханган нийлүүлэх үйл ажиллагаа
3.	Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагаа ("Улаанбаатар төмөр зам" ХНН, Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, "Чингис хаан", "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал, "МИАТ" ТӨХК, "Биокомбинат" ТӨҮГ, Үндэсний дата төвийн нөөц төв, Дипломат төлөөлөгчийн газар, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар түүний ажилтан, албан хаагчдын 10 хүртэлх хувь ажиллах, цагийн хязгаартай)
4.	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
5.	Хууль тогтоох байгууллага, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, гааль, шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын байгууллага, Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаа (ажилтан, албан хаагчдын 10 хүртэлх хувь ажиллах, цагийн хязгаартай)
6.	Теле хичээл, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамжийн төрөлжсөн байгууллага, тур хамгаалах байр, Монголын улаан загалмай нийгэмлэг
7.	Хүнсний үйлдвэрлэл, тээвэрлэлт, түгээлт, худалдаа
8.	Мал, амьтны өвс, тэжээлийн тээвэрлэлт, түгээлт
9.	Геологи, уул уурхай, газрын тосны салбарын хангалт, түгээлт, тээвэрлэлт, лабораторийн үйл ажиллагаа
10.	Сайжруулсан түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, тээвэрлэлт, түгээлт
11.	Банкны цахим болон автомат тооцооны машин
12.	Хэвлэл мэдээлэл (тооны хязгаартай), харилцаа холбоо, шуудан, илгээмж
13.	Зөвшөөрөлтэй харул хамгаалалтын байгууллага
14.	Оршуулгын үйл ажиллагаа